

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар
сарын 25-ны өдрийн А/258 дугаар
тушаалын хавсралт

БАРАА ХУДАЛДАН АВАХ
ТЕНДЕРШАЛГАРУУЛАЛТЫН
БАРИМТ БИЧИГ

2024 он

[УВС АЙМГИЙН УЛААНГОМ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
ЗУРГААДУГААР СУРГУУЛЬ]

УВС АЙМГИЙН УЛААНГОМ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 6-Р
СУРГУУЛИЙН ХҮҮХДИЙН ҮДИЙН ХООЛ ХӨТӨЛБӨРТ БАРАА ХУДАЛДАН АВАХ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер Хүүхдийн үдийн хоол хөтөлбөрт бүтээгдэхүүн нийлүүлэх
шалгаруулалтын
нэр:

Тендер УВАЕБС6/20240102003
шалгаруулалтын
дугаар:

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)	5
1. Тендерийн цар хүрээ.....	5
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг.....	5
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж	5
4. Сонирхогч этгээд, оролцогч	5
5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ	6
6. Нийлүүлэх барааны гарал үүсэл	6
7. Тендер шалгаруулалтын баримт бичиг	6
8. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах	6
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт.....	7
10. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл	7
11. Тендерийн иж бүрдэл.....	7
12. Тендерийн жишиг маягтууд	8
13. Хувилбарт санал	8
14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг	8
15. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг.....	8
16. Чадавхын болон туршлагын шаардлага	9
17. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт	10
18. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ..	10
19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт.....	10
20. Тендерийн валют.....	11
21. Тендер хүчинтэй байх хугацаа	11
22. Тендерийн баталгаа	11
23. Тендер баталгаажуулах, илгээх	11
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа	12
25. Тендерийн талаар тодруулга авах	12
26. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх.....	12
27. Тендерийг үнэлэх	12
28. Арифметик алдааг залруулах.....	12
29. Оролцогчид давуу эрх олгох.....	12
30. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт	13
31. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох.....	13
32. Тендерийг эрэмбэлэх	13

33.	Оролцогчийн чадавхыг дахин магадлах	13
34.	Мэдэгдэл хүргүүлэх	13
35.	Гүйцэтгэлийн баталгаа.....	13
36.	Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах.....	13

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1. Тендерийн цар хүрээ**
- 1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 1.3. Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ.
- 1.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.
- 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг**
- 2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.
- 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж**
- 3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 4. Худалдан авах ажиллагааны цахим систем**
- 4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.
- 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх**
- 5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.
- 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
- 6. Сонирхогч этгээд, оролцогч**
- 6.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
- 6.2. Оролцгчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
- 6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

- 6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
- 6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 7. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ**
- 7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
- 7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
- 7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
- 7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаarahгүй.
- 7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 8. Нийлүүлэх барааны гарал үүсэл**
- 8.1. ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.
- Б.АГУУЛГА**
- 9. Тендер шалгаруулалтын баримт бичиг**
- 9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:
- I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
- II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;
- III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;
- IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;
- V Бүлэг. Тендерийн жишиг маягт;
- VI Бүлэг. Гэрээний нөхцөл.
- 9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.
- 9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.
- 10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**
- 10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.
- 10.2. ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.
- 10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.

- 11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**
- 11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.
- 11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.
- В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**
- 12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**
- 12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.
- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.
- 12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.
- 12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.
- 13. Тендерийн иж бүрдэл**
- 13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.
- 13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
- 13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
- 13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
- 13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
- 13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан өрөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
- 13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
- 13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;
- 13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
- 13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;

		13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
		13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.
		13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
		13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.
14. Тендерийн маяттууд	жишиг	14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.
15. Хувилбарт санал		15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.
16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг		<p>16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.</p> <p>16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.</p> <p>16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> 16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг; 16.3.2. гадаадын иргэн, харьялалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг; 16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг. <p>16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадлана.</p>
17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг		<p>17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.</p> <p>17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.</p> <p>17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.</p> <p>17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.</p>

- 17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.
 - 17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.
 - 17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тонон төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
 - 17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;
 - 17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл;
 - 17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендert ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.
 - 17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендert ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.
 - 17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 18. Чадавхын болон туршлагын шаардлага**
- 18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.
 - 18.2. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

- 18.3. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 18.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
- 19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**
- 19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалzan үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.
- 19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
- 20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**
- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.
- 21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.
- 21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.
- 21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

- 21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- 21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.
- 21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
- 22. Тендерийн валют**
- 22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
- 23. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.
- 23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
- 23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
- 24. Тендерийн баталгаа**
- 24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.
- 24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**
- 25. Тендер баталгаажуулах, илгээх**
- 25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгааг шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.
- 25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

- 25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
- 25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маят 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
- 25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаараахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.
- 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
- 26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.
- Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**
- 27. Тендерийн талаар тодруулга авах**
- 27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
- 28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**
- 28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.
- 29. Тендерийг үнэлэх**
- 29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
- 29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 30. Арифметик алдааг залруулах**
- 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
- 31. Давуу эрх олгох**
- 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.

- | | |
|---|--|
| 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт | 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ. |
| 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох | <p>33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.</p> <p>33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.</p> <p>33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.</p> |
| 34. Тендерийг эрэмбэлэх | 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална. |
| 35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах | <p>35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална.</p> <p>35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.</p> <p>35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.</p> |

E. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- | | |
|---|---|
| 36. Шийдвэр хүргүүлэх | 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ. |
| 37. Гүйцэтгэлийн баталгаа | <p>37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.</p> <p>37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.</p> |
| 38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах | <p>38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.</p> <p>38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.</p> |

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: Увс аймгийн Улаангом сумын Ерөнхий боловсролын 6-р сургууль
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: Хүүхдийн Үдийн хоол хөтөлбөр
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: УВАЕБС6/20240102003
ТШЗ 1.2	<p>Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p>Багц № 1: Гурилан бүтээгдэхүүн</p> <p>Багц № 2:Хүнсний ногоо</p> <p>Багц № 3: Сүүн бүтээгдэхүүн</p> <p>Багц № 4: Мах, махан бүтээгдэхүүн</p> <p>Багц № 5: Хүнсний КГ-ын бүтээгдэхүүн, жимс</p> <p>Багц № 6: Жимсний шүүс</p>
ТШЗ 1.3	Дээрх багцад хамаарах бүтээгдэхүүнийг дотоодын ААН-ээс худалдан авна.
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “ Үзүй ”
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсвийн урсгал зардал
ТШЗ 2.1	<p>Нийт төсөвт өртөг: 168,774,300 Нэг зуун жаран найман сая долоон зуун далан дөрвөн мянга гурван зуун төгрөг</p> <p>Хүүхдийн тоо: 750</p> <p>Багц № 1: 10,100,000 ₮</p> <p>Багц № 2: 12,300,000 ₮</p> <p>Багц № 3: 15,875,500 ₮</p> <p>Багц № 4: 62,400,764 ₮</p> <p>Багц № 5: 58,198,036 ₮</p> <p>Багц № 6: 9,900,000 ₮</p>
Б. АГУУЛГА	
ТШЗ 8.1	<p>Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Хүлээн авагчийн нэр: Ерөнхий боловсролын 6-р сургууль</p> <p>Хаяг: 9-р баг Ерөнхий боловсролын 6-р сургууль</p> <p>Утасны дугаар: 99452191 88580006</p> <p>Цахим шуудангийн хаяг: uvs-erdem@edu.uv.gov.mn</p>

ТШЗ 11.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “ <u>Үгүй</u> ”
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.2	Зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: “ Монгол хэл ”
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “ Зөвшөөрөхгүй ”
ТШЗ 17.4	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: “Үгүй”
ТШЗ 18.1	<p>Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: “Шаардана”</p> <p>Нийт ажилчдын болон барааг хүлээлгэн өгөх ажилтны мэдээлэл, удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадваар, туршлагын талаар шаардагдах мэдээллийг тодорхой бичих, эрүүл мэндийн байдлыг тодорхойлсон мэргэжлийн байгууллагын үзлэг, шинжилгээний бичиг ирүүлэх.</p> <p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: “Шаардлагатай” Сүүлийн 2 жил</p> <p>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: “Шаардана” техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p>Тухайн бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх, зориулалтын тээврийн хэрэгслийн бичиг баримт, фото зураг тухайн оролцогчийн эзэмшигчийн нэр дээр байх</p> <p>Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хавсралтаар ирүүлнэ.</p> <p>Борлуулалтын орлогын хэмжээ: ТШЗ-ны 18.3-т заасан хугацаанд гүйцэтгэсэн нийт борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсвийн 30 хувиас баагүй байх.</p>
ТШЗ 18.2	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардана” ААН-ийн тохирлын гэрчилгээний хуулбар/хугацаа дуусаагүй байх/
ТШЗ 19.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: “Тийм”</p> <ul style="list-style-type: none"> - харилцагч банкны мэдэгдэл; - Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагaa; - сүүлийн хоёр хүртэл жилийн хугацаанд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлан; - сүүлийн хоёр хүртэл жилийн хугацаанд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл. -санхүүгийн тайланд аудит хийлгэх үүрэгтэй оролцогчийн хувьд санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт.

	Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: [сүүлийн 2 жил]
ТШЗ 20.1	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: “Тийм”</p> <ul style="list-style-type: none"> - Барааг өөрөө үйлдвэрлээгүй бол барааг нийлүүлэх боломжтой болохыг нотлох баримт: <ul style="list-style-type: none"> ✓ <i>Max ,сүүний гарал үүслийн гэрчилгээ,шинжилгээний бичиг</i> ✓ <i>Хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалтын сав агуулахын зураг байршил,гэрчилгээний хуулбар,түрээсийн бол 2022-2023 оны түрээсийн гэрээний хуулбар</i> ✓ <i>Нийлүүлэх бүтээгдэхүүнд лабораторийн шинжилгээний бичиг,дүгнэлт гаргуулах</i> ✓ <i>Хүнсний бүтээгдэхүүний чанар,аюулгүй байдлын шинэжилгээний дүгнэлтийн хуулбар</i> <p>Хүний нөөцийн мэдээлэл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ <i>Нийт ажилчдын болон барааг хүлээлгэн өгөх ажилтаны мэдээлэл,удирдах албан тушаалын иргэний үнэмлэхийн хуулбар</i> ✓ <i>Мэргэжлийн үнэмлэх,дипломын хуулбар</i> ✓ <i>Эрүүл мэндийн байлдыг тодорхойлсон мэргэжлийн байгууллагын үзлэг,шинжилгээний бичиг ирүүлэх.Үйлдвэрлэгч ажилтнуудын шинжилгээнд орсон эрүүл ахуй,ариун цэврийн бичиг/цагаан дэвтэр-б сар дутам/</i> <p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ <i>Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл</i> ✓ <i>Гэрээний үүргээ биелүүлсэн талаар өмнөх захиалагчийн үнэлгээ,тодорхойлолт ирүүлэх</i> <p>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж,техник хэрэгсэл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ <i>Үйл ажиллагаа явуулахад ашиглагдаж байгаа техник хэрэгслийн жагсаалт ,фото зураг</i>
ТШЗ 21.5.	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна”
ТШЗ 21.6	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: Incoterms 2020, DDP, бараа хүргэх газар
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 25.5.	<p>ТШЗ-ны 17дугаар зүйлд заасан болон V бүлгийн маягтаас гадна бусад тендерт оролцогчдод ил болгох баримт бичгийн жагсаалт:</p> <ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээ эхээс хийсэн хуулбар 2. Нийлүүлэх барааны үнийн санал,бараа нийлүүлэлтийн хувваарийг батлгаажуулан ирүүлэх.
ТШЗ 26.1.	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2024оны 02 сарын 26-ний өдөр</p> <p>Цаг: 11:00 (орон нутгийн цагаар 10:00)</p>

ТШЗ 26.2.	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: 2024-02-26-ний өдөр</p> <p>Цаг: 11:30 (орон нутгийн цагаар 10:30)</p> <p>Тендер нээх газрын хаяг: Увс аймгийн Улаангом сумын ЕБ-н 6-р сургууль</p>
-----------	---

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

ТШЗ 29.2.	<p>Тендер үнэлэх үндсэн шалгуур үзүүлэлт ашиглах эсэх:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын товч танилцуулга, ажлын туршлага 2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар үйл ажиллагаа эрхлэх чиглэл, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдан борлуулах зөвшөөрөл байх. 3. Нийлүүлэх бүтээгдэхүүний жагсаалт, бүтээгдэхүүн тус бүрийн орц норм нийлүүлэх үнэ. 4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт/эх хувь/ тендер зарласнаас тендер хүлээн авах хүртэлх хугацаагаар авсан байна. 5. Бараа хүргэх тээврийн хэрэгсэлтэй эсэх тээврийн хэрэгслэлийн гэрчилгээний хуулбар, зургийг өнгөтөөр хэвлэж хавсаргах 6. Тендерт оролцогч гэрээний хугацаанд зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарах эрсдлийг өөрөө хариуцах тухай албан бичгээр ирүүлэх 7. Гэрээний хугацаанд ханшийн өөрчлөлт, үйлдвэрлэлийн эрсдлийг нийлүүлэгч тал хариуцна. 8. Үйлдвэрлэгч ажилтнуудын шинжилгээнд орсон эрүүл ахуй, ариун цэврийн бичиг/цагаан дэвтэр-б сар дутам/
-----------	---

**Техникийн
тодорхойлт**

Нийлүүлэх бараа нь доор дурдсан
техникийнтодорхойлолт,
стандартад нийцсэн байна.

Хавсралт

Нэр төрлийн дугаар	Бараа болон холбогдох үйлчилгээний нэр	Техникийн тодорхойлолт болон стандарт тавигдах шаардлага
Багц-1 Гурилан бүтээгдэхүүн	Талх, Төрөл бүрийн нарийн боов	<p>4.1 Бүтээгдэхүүний чанар, хэлбэр, өнгө гадаргуу, амт үнэр зэрэг стандартын шаардлага хангасан үйлдвэрт баталгаажсан жор технологийн зааврыг баримтлан үйлдвэрлэсэн Хүүхдийн сонирхол татахуйц олон төрлийн байна. /Амталгаа ирүүлнэ/ хүнсний бүтээгдэхүүнийг зориулалтын уутанд савлаж, дараах мэдээлэлийг агуулсан шошго хийж битүүмжилнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">• <p>4.2 Үйлдвэрлэгчийн нэр</p> <ul style="list-style-type: none">• Бүтээгдэхүүний нэр, төрөл• Цэвэр жин• Үйлдвэрлэсэн огноо,• Стандартын дугаар• Хэрэглэх аргын заавар <p>Шошголохтой холбогдсон журам MNS6648:20162-ын шаардлага хангасан</p>

	<p style="text-align: center;">Төмс</p>	<p>1.Нийлүүлэх төмс нь орон нутагт тариалагдсан, MNS 258:2006 стандартын шаардлага хангасан байна. 2 Мэргэжлийн хяналтын лабораторит улирлаар шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан 3.Шинэ буюу шинэлэг байдлаа хадгалсан байх 4. Хортон, хөнөөлт шавьжаар гэмтэж, бохирлогдоогүй, бүтэн, хуурай, сортынхоо хэлбэр, дүрсийг хадгалсан байх 5.Хальс нь шалбарсан төмс 10 хувиас ихгүй, ногоорсон төмсгүй, пестицидийн үлдэгдэлгүй байх 6.Гадны ямар нэг үнэртэй, химиин бодисоор бохирлогдсон байж болохгүй. 7.Төмсний голч хэмжээ 35-55 мм, 55мм-ээс дээш байна. 8 Төмсийг норох, хөлдөхөөс хамгаалж бүтээлэгтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. 9 Бүтээгдэхүүнийг ажлын 5 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ. 10. Намрын улиралд шинэ ургацын төмс нийлүүлэх.</p>
	<p style="text-align: center;">Байцаа</p>	<p>1.Нийлүүлэх байцаа нь орон нутагт тариалагдсан, MNS0255:2007 стандартын шаардлага хангасан монгол байцаа байх 2. Мэргэжлийн хяналтын лабораторит улирлаар шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан байх. 3. Байцаа нь нягтрал сайтай, бүтэн, цэвэр, өвчлөөгүй, хортон, хөнөөлт шавьжаар гэмтэж, бохирлогдоогүй, механик элдэв хольцгүй, гадны үнэр амтгүй, сортынхоо хэлбэр, дүрсийг хадгалсан байна. 4.Хадгалсан байцааг нийлүүлэхдээ гадна талын муудсан навчийг авч цэвэрлэсэн байх ба хөлдөлт, хайрагдалтгүй байна.</p>
Багц -2 Хүнсний ногоо	<p style="text-align: center;">Сонгино Сармис</p>	<p>1..Нийлүүлэх сонгино нь MNS 0260:1982 стандартын шаардлага хангасан, монгол, орос сонгино байна. 2 Мэргэжлийн хяналтын лабораторит улирлаар шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, 3.Сонгино нь механик элдэв хольцгүй, хортон, хөнөөлт шавьжаар гэмтэж, бохирлогдоогүй, эрүүл, цэвэр, хуурай, сортынхоо хэлбэр, дүрсийг хадгалсан байна. 4.Булцуу нь нягт, ургаж, соёолоогүй, ялзраагүй, хатаж чийгээ алдаагүй, ааг амт сайтай байна. 5.Сонгиныг стандартын шаардлага хангасан шуудай, торон уутанд зэрэг, сортоор нь ялгаж савласан байна. 6 .Сонгиныг норох, хөлдөхөөс хамгаалсан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. 7.Бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ</p>

		8. Намрын улиралд шинэ ургацын сонгино нийлүүлэх.
	Лууван	<p>1. Нийлүүлэх лууван нь орон нутагт тариалагдсан , MNS 0271:1982 стандартын шаардлага хангасан 1сорт байна.</p> <p>2 Мэргэжлийн хяналтын лабораторит улирлаар шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан,</p> <p>3.Лууван нь нягт, шүүслэг, хөндийрөөгүй, модорч хөгшрөөгүй, үрчийгээгүй, соёолоогүй, гэмтээгүй, ялзраагүй, механик элдэв хольцгүй, гадны үнэр амтгүй байна.</p> <p>4. Савлалт нь хуурай, цэвэр, даавуун шуудайд савласан байна.</p> <p>5. Лууванг норох, хөлдөх, гэмтэхээс хамгаалж тээвэрлэнэ.</p> <p>6. Бүтээгдэхүүнийг ажлын 5 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.</p> <p>7. Намрын улиралд шинэ ургацын лууван нийлүүлэх.</p>
	Шар, хүрэн манжин	<p>1. Нийлүүлэх манжин нь орон нутагт тариалагдсан , MNS 0268:1973 стандартын шаардлага хангасан /1 дүгээр зэргийн</p> <p>2. Мэргэжлийн хяналтын лабораторит улирлаар шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан,</p> <p>3.Ил болон хамгаалагдсан хөрсөнд ургуулсан манжинг нийлүүлнэ..</p> <p>4.Хортон, хөнөөлт шавьжаар гэмтээгүй, үндэс үр нь шинэ бүтэн,эрүүл, хагаралтгүй,</p> <p>5.хөгшрөөгүй, наалдсан шороогүй, хуурай, сортынхоо хэлбэр, дүрсийг хадгалсан байна.</p> <p>6. Савлалт нь хуурай, цэвэр, шуудайлж савласан байх.</p> <p>7.Ногоог норох, хөлдөх гэмтэхээс хамгаалж тээвэрлэнэ.</p> <p>7.Бүтээгдэхүүнийг ажлын 5 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ</p> <p>8. Намрын улиралд шинэ ургацын манжинг нийлүүлэх.</p>

<p>Багц-3 Сүү,сүүн бүтээгдэхүүн</p>	<p>Шингэн сүү ,Тараг,аарц,</p>	<p>1.1 Сүү, сүүн бүтээгдэхүүн нь хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим MNS CAC 1:2003 стандартын шаардлага хангасан эрүүл ахуйн тохиромжтой нөхцөлд бэлтгэсэн байна. 2 Сүү нь түүхий сүүний техникийн шаардлага MNS 4228:2003 стандартыг хангасан байна. 3 Түүхий сүү нь малаас хүнд халдвартын өвчин болон малын гоц халдварт өвчнөөр өвчлөөгүй эрүүл бүсээс бэлтгэсэн байна. 4 Сүү, сүүн бүтээгдэхүүн нь Мэргэжлийн хяналтын лабораторит улирал тутам шинжлүүлсэн байх 5.Зориулалтын сав, баглаа, боодолтой байна. 6.Хүнсний нэмэлт агуулаагүй байна. 7.Ариун цэврийн шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. 8.Тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын явцад технологийн горимыг чанд мөрдөнө. 9. Малын вакцин, тарилга туулгад хамрагдсан тухайд бүтээгдэхүүнийг нийлүүлэхгүй байх ба урьдчилан мэдэгдэнэ. 10. Бүтээгдэхүүний хэрэглэх заавар, зөвлөмж зэрэг нэмэлт мэдээллийг дагалдуулж болно. 12 Нийлүүлэгдэх тараг нь эсэг цагаан идээ техникийн шаардлага MNS 4230:2003 , бяслаг, аарц, ааруул нь уураглаг цагаан идээ техникийн шаардлага MNS 4230:2003 стандартууд болон эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан байна. 13. Үйлдвэрийн болон уламжлалт аргаар бэлтгэсэн, нэгэн жигд бие бүтэцтэй, тослог зохих түвшинд байна. 14.Цагаан өнгөтэй, шинэлэг байдлаа хадгалсан, нэгэн жигд бие бүтэцтэй, тослог зохих түвшинд байна. 15.Бүтээгдэхүүнийг ажлын өдөр хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.</p>
<p>Багц-4 Мах махан бүтээгдэхүүн</p>	<p>Хонь, үхрийн мах</p>	<p>1.Ухэр, хонины 1дүгээр зэргийн, өнгө, үнэр, биет байдал, гадаргуу, хэлбэр алдагдаагүй мах байна 2.Махыг хэсэглэж ангилсан байдлаар нийлүүлэх тохиолдолд MNS 2456:2009, MNS 2457:2009 стандартуудын шаардлагыг хангасан байна 3.Эрүүл ахуй, аюулгүй байдлын үндсэн шаардлага хангасан, эрүүл малаас бэлтгэсэн байна. 4.Мал эмнэлэг, гарал үүслийн гэрчилгээ, хүнсний лабораторийн шинжилгээний бичигтэй байна. 5.Загсаасан буюу сэrvээсэн эсвэл хөргөсөн, хөлдөөсөн мах байна. 6.Нөхирч хурсан цус, сэвс, үс, шороо зэрэг гадны бохирдолгүй, гадаргуу нь урагдаж гэмтээгүй байна. 7.Эрүүл ахуйн шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.</p>

		<p>8.Дулааны улиралд зориулалтын хөргүүрт хадгалах</p> <p>9.Тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын явцад технологийн горимыг чанд мөрдөнө.</p> <p>10.Бүтээгдэхүүнийг ажлын 7 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.</p>
Багц-5 Хүнсний Кг-ын бүтээгдэхүүн, Жимс	1,2-р гурил Дээд гурил	1. Хадгалалт сайн, Монгол улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн, буудайн гурил байх, эрүүл ахуйн шаардлага хангасан шинжилгээний бичигтэй, илчлэг 328 ккал, чийглэг 15,5%, цавуулаг 26%-с багагүй. 324 ккал, чийглэг 22%
	Лапша гоймон 3 кг	100 гр бүтээгдэхүүнд: Уураг 13,1гр, тослог 1,1гр, нүүрс ус 73гр, илчлэг 341 ккал, чийглэг 14%, хадгалалт сайн, стандартын шаардлага хангасан шинэ бүтээгдэхүүн байх
	Орос гоймон 5кг	100 гр бүтээгдэхүүнд: Уураг 10,4гр, тослог 1,1гр, нүүрс ус 71,5гр, чийглэг 14, хадгалалт сайн, стандартын шаардлага хангасан шинэ бүтээгдэхүүн байх
	Шпагети гоймон	100 гр бүтээгдэхүүнд: Уураг 11гр, тослог 1,1гр, нүүрс ус 74,5гр, илчлэг 362 ккал, хадгалалт сайн, стандартын шаардлага хангасаншинэ бүтээгдэхүүн байх
	Цагаан будаа	MNS ISO 7301:2000 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх,
	Шар будаа	MNS 0533:1998 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх
	Хөц будаа	MNS 4515:1997 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх
	Гурвалжин будаа	MNS 6511:2015 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх
	Овьёос хэмэгдэс	MNS ISO 6659-2003 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх
	Элсэн чихэр	MNS CAC 212:2014 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх
	Бүх төрлийн жигнэмэг	MNS 0158:1985 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой

		хэмжээ агуулагдсан байх
	Ургамлын тос	MNS SAC 23-98 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх
	Оливын тос	MNS SAC 23-98 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх
	Хуурай цай	“Гүржи ногоон” цайтай дүйцэхүйц сайн чанарын ,эрүүл ахуй, ариун цэврийн стандарт шаардлагад нийцсэн
	Давс	Эх орны үйлдвэрийн давстай дүйцэхүйц,эрүүл ахуйн стандарт шаардлагад нийцсэн, сайн чанарын иоджуулсан давс
	Исгэгч	Сайн чанарын эрүүл ахуй, ариун цэврийнстандарт шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн байна
	Сод	Сайн чанарын эрүүл ахуй, ариун цэврийнстандарт шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн байна
	Вандуй ,эрдэнэ шиш	Сайн чанарын эрүүл ахуй, ариун цэврийнстандарт шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн байна.
	Үзэм	Гадаад байдал нь элдэв толбо үүсээгүй, тухайн жимсний сортонд тохирсон өнгө үзэмж хэлбэр хэмжээтэй гадны элдэв амт үнэргүй хорчийж хатаагүй,хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтийг бүрэн хангасан,
	Далайн байцай	Солонгос улсад үйлдвэрлэгдсэнбүтээгдэхүүнтэй дүйцэхүйц, Сайн чанарын,эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн
	Бусад нэр төрөл / Жимс:Алим/Белги,Польш улс/жонны сорт/ гэхмээт,Жүрж,Ванан/орос/,помидор,Мандарин гэх мэт	Хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүн нийлүүлэх, дагалдах шинжилгээний бичгүүдийг нийлүүлэлт тухай бүрд тогтмол өгч байх шаардлагатай.
	Өндөг	MNS 0095 : 1977 стандарт хангасан байх шаардлагатай

Багц-6 Жимсний шүүс	Нэрсний шүүс	<p>MNS СAC103-1999 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх, зориулалтын саванд савлаж, дараах мэдээлэлийг агуулсан шошго хийж битүүмжилнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Үйлдвэрлэгчийн нэр • Бүтээгдэхүүний нэр, төрөл • Цэвэр жин • Үйлдвэрлэсэн огноо, • Стандартын дугаар • Хэрэглэх аргын заавар <p>Шошголохтой холбогдсон журам MNS6648:20162-ын шаардлага хангасан</p>
	Аньсний шүүс	<p>MNS 1977-1986 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх, зориулалтын саванд савлаж, дараах мэдээлэлийг агуулсан шошго хийж битүүмжилнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Үйлдвэрлэгчийн нэр • Бүтээгдэхүүний нэр, төрөл • Цэвэр жин • Үйлдвэрлэсэн огноо, • Стандартын дугаар • Хэрэглэх аргын заавар <p>Шошголохтой холбогдсон журам MNS6648:20162-ын шаардлага хангасан</p>
	Чацаргана жимсээрээ	<p>MNS0916-2011стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх, зориулалтын саванд савлаж, дараах мэдээлэлийг агуулсан шошго хийж битүүмжилнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Үйлдвэрлэгчийн нэр • Бүтээгдэхүүний нэр, төрөл • Цэвэр жин • Үйлдвэрлэсэн огноо,

		<ul style="list-style-type: none"> • Стандартын дугаар • Хэрэглэх аргын заавар <p>Шошголохтой холбогдсон журам MNS6648:20162-ын шаардлага хангасан</p>
	Үхрийн нүдний шүүс	<p>MNS CAC103-1999 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх, зориулалтын саванд савлаж, дараах мэдээлэлийг агуулсан шошго хийж битүүмжилнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Үйлдвэрлэгчийн нэр • Бүтээгдэхүүний нэр, төрөл • Цэвэр жин • Үйлдвэрлэсэн огноо, • Стандартын дугаар • Хэрэглэх аргын заавар <p>Шошголохтой холбогдсон журам MNS6648:20162-ын шаардлага хангасан</p>

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

БАГЦ 1: Гурилан бүтээгдэхүүн:10,100,000₮

[Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө]

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжи х нэгж	ТШӨХ-д заасан бараагхүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийнсанал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
1	Талх амтлаг	Захиалгын тоогоор	ш	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
2	Талх хөх тариа	Захиалгын тоогоор	ш	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
3	Боов төрөл бүрийн,жигнэмэг/ 0,45-0,9кг/	Захиалгын тоогоор	уут	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	

БАГЦ 2: Хүнсний ногоо: 12,300,000₮

[Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө]

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийнсанал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
1	Төмс	Захиалгын тоогоор	кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
2	Сонгино	Захиалгын тоогоор	кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
3	Байцаа	Захиалгын тоогоор	кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
4	Өргөст хэмх	Захиалгын тоогоор	кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
5	Лууван	Захиалгын тоогоор	кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	

6	Чинжүү	Захиалгын тоогоор	кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
7	Манжин шар	Захиалгын тоогоор	кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
8	Сармис	Захиалгын тоогоор	кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
9	Улаан лооль	Захиалгын тоогоор	кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	

БАГЦ 3: Сүү сүүн бүтээгдэхүүн:15,875,500₮

[Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө]

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан бараагхүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийнсанал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
1	Сүү	Захиалгын тоогоор	кг	Улаангом сумын б-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
2	Тарааг	Захиалгын тоогоор	кг	Улаангом сумын б-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
3	аарц	Захиалгын тоогоор	кг	Улаангом сумын б-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	

БАГЦ 4: Мах махан бүтээгдэхүүн:62,400,764₮

[Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө]

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан бараагхүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийнсанал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
1	Үхрийн мах	Захиалгын тоогоор	Kг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
2	Хонины мах	Захиалгын тоогоор	Kг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	

БАГЦ 5: Килограммын бүтээгдэхүүн , жимс :58,198,036₮

[Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хуртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө]

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан бараагхүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийнсанал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
1	Хүүхдийн будаа	Захиалгын тоогоор	Кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
2	гоймон	Захиалгын тоогоор	Кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
3	Давс	Захиалгын тоогоор	Кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
4	Гурил 1,2-р ;дээд	Захиалгын тоогоор	Кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
5	Гурил бүхэл үр	Захиалгын тоогоор	Кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
6	Ногоон цай	Захиалгын тоогоор	Ш	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
7	Үзэм орос	Захиалгын тоогоор	Кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	

8	Хөц будаа	Захиалгын тоогоор	Кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
9	Цагаан будаа	Захиалгын тоогоор	Кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
10	Шар будаа	Захиалгын тоогоор	Кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
11	Гурвалжин будаа	Захиалгын тоогоор	Кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
12	Гоймон шпагета	Захиалгын тоогоор	Кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
13	Гоймон хэлбэртэй	Захиалгын тоогоор	Кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
14	Элсэн чихэр	Захиалгын тоогоор	Кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	

15	Масло 82%	Захиалгын тоогоор	Кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
16	Ургамлын тос /олейна/	Захиалгын тоогоор	л	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
17	Исгэгч /орос/	Захиалгын тоогоор	ш	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	

18	Вандуй	Захиалгын тоогоор	Ш	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
19	Молоко	Захиалгын тоогоор	Л	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
20	Варень	Захиалгын тоогоор	Ш	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
21	Далайн байцаа солонгос	Захиалгын тоогоор	Ш	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
22	Овьёсны хэмхтэс	Захиалгын тоогоор	Кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
23	Цайны печень	Захиалгын тоогоор	Кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
24	Жигнэмэг	Захиалгын тоогоор	Кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
25	Оливын тос	Захиалгын тоогоор	Л	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
26	Өндөг	Захиалгын тоогоор	Ш	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
27	Жүрж,Алим ,Банан гэх мэт	Захиалгын тоогоор	Кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	

БАГЦ 6: жимсний шүүс:9,900,000₮

[Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө]

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан бараагхүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийнсанал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
1	Үхрийн нүдний шүүс	Захиалгын тоогоор	Л	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
2	Нэрсний шүүс	Захиалгын тоогоор	Л	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
3	Аньсны шүүс	Захиалгын тоогоор	Л	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	
4	Чацаргана жимсээрээ	Захиалгын тоогоор	кг	ЕБ-н 6-р сургууль хүнсний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	2025 оны 01 сарын 31	

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч ТӨХ-д тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна ТШЗ-ны 32.1.6-д заасан нэг буюу хэд хэдэн хүчин зүйлийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр бусад аливаа шалгуур үзүүлэлт, аргачлалыг үнэлгээнд харгалзахгүй.

1. Бараа нийлүүлэлтийн хуваарь: **Ашиглана**

Хэрэв “ашиглах” бол: Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (барааны нийлүүлэлт хийх хамгийн эхний өдрөөс хойш нийлүүлэлт хийвэл зохих хамгийн сүүлчийн өдрийг оролцуулан) нийлүүлэгдсэн байх шаардлагатай. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанаас өмнө нийлүүлэх санал ирүүлсэн тендерт урамшуулал буюу үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл байдал олгохгүй.

Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарьт зааснаас хоцорч нийлүүлэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд [хувь бич]–иар тооцож тендерийн үнэ дээр нэмнэ.

Барааг хуваарьт зааснаас 1 хонгоос илүү болон барааг “нийлүүлтийн хуваарь”-т хугацааны дагуу ирүүлээгүй болон хоцроож хүргэхийг санал болгосон тендерээс татгалзана. Харин ТӨХ-д тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон бараа нийлүүлэлтийн хуваариас урагш болон хойш нийлүүлэхээр санал болгосон тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.

2. Тендерт санал болгосон барааны урсгал зардал, үйл ажиллагааны баталгаа болон үр ашигтай байдал: “**Ашиглахгүй**”
3. Тендерт санал болгосон барааны борлуулалтын дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: “**Ашиглахгүй**”
4. Тендерийн дагуу санал болгож байгаа барааны гол эд анги, зайлшигүй шаардлагатай сэлбэг хэрэгсэл болон үйлчилгээний зардал: “**Ашиглахгүй**”

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД

Маягт 1. Тендер илгээх маягт

Маягт 2. Барааны үнийн задаргаа

Маягт 3. Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Маягт 4. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 5. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 6. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

Үес аймгийн Улаангом сумын ЕБ-н 6-р сургууль-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй;
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [30 ба түүнээс дээш хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна.¹
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

¹ Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

*[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг]:*

Хаяг:

Маягт 2 Барааны үнийн задаргаа

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
№	Барааны нэр	Гарал үүслийн улс ²	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4x6)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ	Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)	Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх ³
1										Тийм/Үзүй
2										
...										
								Тендерийн нийт үнэ		

*[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг, байгууллагын
тамга, тэмдэг]:*

² ТШЗ-ны 18.6.2-ын дагуу ирүүлсэн баримт бичигт дурдсан барааны гарал үүслийн талаарх мэдээлэлтэй ижил байна.

³ Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт “тийм” гэж бөглөсөн бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.

Маягт 3

Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 4

Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 6

Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох үйлчилгээг худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэрээ байгуулах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалттай танилцаж, судалсан байх шаардлагатай болохыг анхаарна уу.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ.ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:

- 1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;
- 1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;
- 1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
- 1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
- 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;
- 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
- 1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.
- 1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;
- 1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;
- 1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;
- 1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;
- 1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй

	<p>харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;</p> <p>1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;</p> <p>1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.</p>
Гэрээний тайлбар	<p>1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:</p> <p>1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.</p> <p>1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.</p> <p>1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлахад бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлахад боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.</p> <p>1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.</p> <p>1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.</p>
Бараа нийлүүлэх	<p>ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ</p> <p>2.1 Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.</p> <p>2.2 Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй</p>

	шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.
Бараа нийлүүлэх газар	2.3 ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.
Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах	2.4 Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.
Барааг хүлээлгэн өгөх	2.5 Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.
Барааны гарал үүслийн улс	2.6 Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.
Баглаа боодол	2.7 Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно: 2.7.1 Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй; 2.7.2 Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон. 2.8 Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно. 2.9 ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй. 2.10 Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ. 2.11 Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ. 2.12 Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна. 2.13 Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна. 2.14 Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана. 2.15 Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно.

	2.16	Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө.
Худалдааны нөхцөл	2.17	Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана.
	2.18	ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
Гүйцэтгэлийн баталгаа	2.19	Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Нийлүүлэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн З хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Нийлүүлэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.
	2.20	Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Нийлүүлэгчийн Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангулна:
	2.20.1	Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;
	2.20.2	Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;
	2.20.3	Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.
	2.21	Захиалагч гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангулсан нь Нийлүүлэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.
	2.22	ГЕН-ийн 2.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Нийлүүлэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.
	2.23	Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 4.11-д заасан Чанарын баталгаа гаргасан тохиолдолд Гүйцэтгэлийг баталгааг чөлөөлнө.
	ГУРАВ. ЗАХИАЛАГЧ	
Барааг хүлээн авах	3.1	Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
Шалгалт, туршилт	3.2	Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.
	3.3	Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.

- | | |
|-----------------------------------|--|
| | <p>3.4 ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.</p> <p>3.5 Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.</p> <p>3.6 Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.</p> |
| Гэрээний үнэ | <p>3.7 Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>3.8 Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.</p> |
| Төлбөр төлөх | <p>3.9 Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.</p> <p>3.10 Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.</p> <p>3.11 Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.</p> <p>3.12 Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.</p> <p>3.13 ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.</p> <p>3.14 Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.</p> <p>3.15 Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.</p> |
| Захиалагчийн хүлээх эрсдэл | <p>ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА</p> <p>4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <p>4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;</p> <p>4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаarahгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.</p> |
| Даатгал | <p>4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын</p> |

	гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.
Доголдол	<p>4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.</p> <p>4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.</p> <p>4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.</p> <p>4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бур Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.</p> <p>4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.</p> <p>4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.</p> <p>4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.</p>
Чанарын баталгаа	<p>4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.</p> <p>4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.</p> <p>4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.</p> <p>4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.</p> <p>4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.</p> <p>4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.</p> <p>4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.</p>
Алданги	4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа

	хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
Оюуны өмчийн эрх зөрчих	4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.
Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал	4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана. 4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.
Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа	4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна. 4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна. 4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.
Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл	4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна. 4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.
	ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ
	5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй: 5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;

- | | |
|--|---|
| | <p>5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;</p> <p>5.1.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.</p> <p>5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.</p> |
| | <p>5.2. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига өгсөн, запилах гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.</p> <p>5.3. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.</p> <p>5.4. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.</p> |
| Гэрээнээс татгалзах,
гэрээг цуцлах мэдэгдэл | <p>5.5. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.</p> |
| ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ | |
| Төлөөлөгч | <p>6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.</p> <p>6.3. Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.</p> |
| Туслан гүйцэтгэгч | <p>6.5. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>6.6. Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын догоилдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.</p> |
| Нууцлал | <p>6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал</p> |

	зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
Мэдэгдэл	<p>6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.</p> <p>6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.</p> <p>6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.</p> <p>6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:</p> <p>6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;</p> <p>6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.</p> <p>6.13. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.</p> <p>6.14. ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.</p> <p>6.15. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:</p> <p>6.15.1. ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан;</p> <p>6.15.2. үнийн тохируулга хийсэн.</p> <p>6.16. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.</p> <p>6.17. ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.</p> <p>6.18. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.</p> <p>6.19. Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.</p>
Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах	
Маргаан шийдвэрлэх	

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.5.	Бараа нийлүүлэх газар: Увс аймаг Улаангом сумын ЕБ-ын 6 дугаар сургууль 9-р баг
ГЕН 2.6.	Бараа нийлүүлэх хугацаа:2024.03.04-2025.01.31
ГЕН 2.10.	Бараа хүлээлгэн өгөх нөхцөл: Увс аймаг Улаангом сумын ЕБ-н 6 дугаар сургуулийн агуулахад өөрийн унаагаар хүргэж хүлээлгэж өгөх
ГЕН 2.14.	Баглаа, боодол: Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн, хур тунадас болон бусад бүх нөхцөлийг хангалттай тээвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгоходоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлсийг харгалзсан байна.
ГЕН 2.17.	Худалдааны нөхцөл: Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ. [Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 21.6-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Худалдааны нөхцөл (Incoterms)
ГЕН 3.9.	Төлбөр төлөх хугацаа: Сар бүрийн 25-нд тооцоо нийлж баталгаажуулан ажлын 3 өдөрт багтаан гүйлгээ хийгдэнэ. Санхүүжилт хийгдсэн огноогоос хамаарч өөрчлөгдж болно.

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэрийг бичих]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дунг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч **[Нийлүүлэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Доор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
 - 3.6. Техникийн тодорхойлолт;
 - 3.7. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:
 - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр**

Тендер шалгаруулалтын төрөл: Бараа

Тендер шалгаруулалтын нэр: **Хүүхдийн үдийн хоол**

Тендер шалгаруулалтын дугаар: **УВАЕБС6/20240102003**

Нийт төсөвт өртөг: **168,774,300**

Тендер шалгаруулалтын арга: Нээлттэй

- Увс Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан хуулийн этгээдийг Сургуулийн хүүхдийн үдийн хоолны материал нийлүүлэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.
- Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: “**Тийм**”

Багц №1: Гурил гурилан бүтээгдэхүүн

Багц №2: Хүнсний ногоо

Багц №3: Сүү сүүн бүтгээгдэхүүн

Багц №4: Мах махан бүтээгдэхүүн

Багц №5: Хүнсний кг-ын бүтээгдэхүүн, жимс

Багц №6: Жимсний шүүс

Дотоодын давуу эрх тооцох эсэх. Тооцно.

Гадаадын этгээд тендер ирүүлэх: Эрхгүй

Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендерийн баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд тендерийн баримт бичгийг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50000 төгрөгийг цахим систем ашиглан төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно.

Тендерийг **2024-02-26-ны өдрийн 11:00 цагаас /орон нутгийн цагаар 10:00/ өмнө www.tender.gov.mn** хаягаар тендерийн баримт бичигт заасан журмаар ирүүлэх ба тендерийн нээлтийг **2024-02-26-ны өдрийн, 11:30 цагт / орон нутгийн цагаар 10:30 цаг / зохион байгуулна.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсвэл доорх утсаар авч болно.

Увс аймгийн Улаангом сум Ерөнхий боловсролын 6-р сургууль

Утас: 95807543 88580006